

Солонгост оршин суугаа гадаад иргэд(60-с дээш нас) Корона19 вакцины 4 дэх(нэмэлт) тунд хамрагдах тухай заавар

Омикорон вирусын тархалт ихсэж байгаатай холбоотойгоор ахмад настнуудын халдварлалт, нас баралтын тоо өсөж байна. Корона19-ын халдварлалтаас үүдэлтэй өвчийг хүндрэл болон нас баралтаас хамгаалах зорилгоор 60-с дээш насны Солонгост оршин суугаа гадаад иргэдэд Корона19 вакцины 4 дэх тун буюу нэмэлт вакцинжуулалт хийх болсоныг мэдэгдэж байна.

■ Вакцинжуулалтад хамрагдах хүн

- 60нас ('62.12.31. өмнө төрсөн)-с дээш насныхан дотор дотоодод болоод гадаад оронд 3 дахь тун хийлгээд 4сар(120хоног) өнгөрсөн хүн, ялангуяа хүндрэх аюултай 80-с дээш насны өндөр настангуудыг 4 дахь вакцинжуулалтад идэвхтэй хамрагдахыг зөвлөж байна.

* 3 дахь удаагийн вакцинжуулалтын өмнө болон дараа Корона19-ын халдвар авч байсан бол өөрөө хүсэх тохиолдолд вакцинжуулалтад хамрагдаж болно.

■ Вакцины төрөл, вакцинжуулалт хоорондын зай

- mRNA вакцин (Pfizer, Moderna) болон Novavax

- 60-с дээш настангуудын дотор 3 дахь тун хийлгэснээс хойш 4сар(120хоног) өнгөрсөн байх

Зөвхөн, олноор халдвар тархах магадлалтай асрамжийн эмнэлэг болон байгууламж(сэтгэцийн эрүүл мэндийн байгууламж)ийн халамжид байгаа хүн болон вакцин хоорондын хугацааг богиносгох шаардлагатай дархлааны хомстолтой хүн нь 3 дахь тунгаас хойш 3сар(90хоног) өнгөрвөл хийлгэх боломжтой

■ Тарилга хоорондын зай болон вакцинжуулалт хийх газар

- **Урьдчилсан захиалга 2022.4.18(Даваа)-с авч эхлэх ба захиалгат тарилга 2022.4.25(Даваа)-с хийгдэнэ.**

- Түргэвчилсэн тарилга нь тухайн эмнэлгийн байгууллагад үлдэгдэл вакцин байгаа тохиолдолд **2022.4. 14(Пүрэв) өдрөөс хийгдэх боломжтой.**

- Тарилга хийгдэх газар нь улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдлаас шалтгаалахгүйгээр **Корона 19 вирус**аас урьдчилан сэргийлэх тарилга хийж байгаа тул бүх эмнэлгийн байгууллага дээр хийнэ. Зөвхөн, эмнэлгийн байгууллага хүрэлцэхгүй тохиолдолд эрүүл мэндийн газарт хийгдэнэ.

■ Захиалга өгөх арга

1. Солонгост үндсэн болон 3 дахь тунд хамрагдсан 60-с дээш насны гадаад иргэн

1) Гадаадын иргэний бүртгэлтэй гадаад иргэд : Үндсэн вакцинжуулалт хийлгэсэнтэй адил онлайн болон утсаар урьдчилан захиалга өгөх боломжтой.

① Онлайн захиалга : Корона19 вирусын эсрэг вакцины урьдчилсан захиалгын систем (<https://ncv.kdca.go.kr>) руу нэвтрэн орж өөрөө болон төлөөлөн захиалах

② Утсан захиалга: Халдварт өвчнийг хянах урьдчилан сэргийлэх газрын лавлах утас (☎1339) болон орон нутгийн засаг захиргаа тус бүрийн лавлах төвд утсаар захиалах

③ Түргэвчилсэн захиалга : Эмнэлгийн байгууллагын урьдчилсан бүртгэлд (утсаар шалгах) бүртгүүлсний дараа тухайн өдөр тарилга хийлгэх

* SNS-р үлдэгдэл вакцины захиалга хийх боломжтой.

2) Гадаадын иргэний бүртгэлгүй иргэд(Хууль бусаар оршин суугаа иргэд) : Үндсэн вакцинжуулалт болон 3 дахь тун хийлгэхдээ эрүүл мэндийн газраас авсан түр хяналтын дугаараа хэрэглэн утсаар захиалах болоод тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн газар) биечлэн очиж захиалга өгөх.

* түр хяналтын дугаарыг өгөхөд паспорт болон гадаадын иргэний үнэмлэх зэрэг хувийн бичиг баримтыг шаардахгүй.

2. Гадаад оронд үндсэн болон 3 дахь тун хийлгэсэн 60-с дээш насны гадаад иргэн(90хоногоос доош хугацаагаар оршин сууж байгаа гадаад иргэн)

- Хувийн бичиг баримтын хамт ойрхон эрүүл мэндийн газар биечлэн очих, түр хяналтын дугаар авч гадаад оронд хийлгэсэн тарилгын талаарх бүртгэлээ хийлгэсний дараа утсаар болон тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн газар) биечлэн очиж захиалга өгөх.

※ Жич

- Хувь хүний мэдээллийг зөвхөн вакцинжуулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдэгдэх үүргээс чөлөөлөх журмын дагуу Цагаачлалын албанд хууль бусаар оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.

- Бусад тодорхой мэдээллийг Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газар Корона19 вакцинжуулалт Нүричиб (<https://ncv.kdca.go.kr>)-с шалгана уу